

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур үйлдвэр, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/202/НА-СТА-ОНӨҮГ

Цахим
хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор: Г.Нандинжаргал
Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер : Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayrkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantuguss@audit.gov.mn

Си Эс Ай аудит ХХК-ийн захирал: М.Сэвжидмаа
Утас: 19001981. Цахим хаяг: csi_sevjee@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 582
танай _____-ны № _____-т

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ЫН
ЗАХИРАЛ Б.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны Багануур үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Багануур үйлдвэрлэл технологийн парк ХК нь 700.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 669.1 сая төгрөгийн зардал гарган 40.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Төрийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд буюу Хувьцаат компани /хаалттай ХК/ бөгөөд зорилтот түвшиний төлөвлөгөө гүйцэтгэлийг, төсвийн гүйцэтгэлээр төлөвлөж тайлагнасан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		9,836,942.64
1.1.2	Дансны авлага		
1.1.6	Бараа материал	5,843,600.00	13,699,832.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10	Мал амьтад		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,843,600.00	23,536,775.14
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	237,755,095.32	245,902,945.12
1.2.2	Биет бус хөрөнгө	109,250,838,720.00	109,265,148,720.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	109,488,593,815.32	109,511,051,665.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	109,494,437,415.32	109,534,588,440.26
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: - төрийн	77,246,400,000.00	77,246,400,000.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	32,248,037,415.32	32,288,188,440.26
2.3.11	Эздийн өмчийн дүн	109,494,437,415.32	109,534,588,440.26
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	109,494,437,415.32	109,534,588,440.26

2.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
А	Б	1	2
1	Борлуулалтын орлого (цэвэр)	32,563,876,561.46	769,947,100.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	32,563,876,561.46	769,947,100.00
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	466,761,932.14	668,544,052.54
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
12.1	Зардлын дүн		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(60,266,666.83)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(985,355.69)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	32,097,114,629.32	40,151,024.94
19	Орлогын татварын зардал		
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	32,097,114,629.32	40,151,024.94
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	32,097,114,629.32	40,151,024.94
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	32,097,114,629.32	40,151,024.94
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Багануур үйлдвэр, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01 сарын 31	77,246,400,000.00						150,922,786.00	77,397,322,786.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл	77,246,400,000.00						150,922,786.00	77,397,322,786.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							32,097,114,629.32	32,097,114,629.32
2024 оны 12 сарын 31	77,246,400,000.00						32,248,037,415.32	109,494,437,415.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл	77,246,400,000.00						32,248,037,415.32	109,494,437,415.32
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							40,151,024.94	40,151,024.94
2025 оны 12 сарын 31	77,246,400,000.00						32,288,188,440.26	109,534,588,440.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
А	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	447,109,894.61	700,000,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	447,109,894.61	700,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	440,389,894.61	633,673,057.36
1.2.1	Ажиллагчдад төлсөн	350,602,812.90	486,155,456.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,304,427.11	54,556,284.40
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	12,155,179.60	20,490,912.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	34,535,375.00	24,228,320.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн		
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,792,100.00	48,242,084.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,720,000.00	66,326,942.64
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8	Бусад		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,720,000.00	56,490,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,720,000.00	56,490,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,720,000.00)	(56,490,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.4	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.5	Бусад		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		9,836,942.64
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,836,942.64

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Үзүүлэлт	2025 он			
		Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	700,000,000.00	769,947,100.00	69,947,100.00	110.0
	Санхүүжилтийн орлого		700,000,000.00	700,000,000.00	
	Үнэ төлбөргүй хүлээж авсан		69,947,100.00	69,947,100.00	
	Ашиг		40,151,024.94	40,151,024.94	
	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700,000,000.00	668,544,052.54	(31,455,947.46)	95.5
1	Зориулалт /Үндсэн үйл ажиллагаа/	700,000,000.00	668,544,052.54	(31,455,947.46)	95.5
1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	492,930,100.00	486,155,456.00	(6,774,644.00)	98.6
	Үндсэн цалин	291,718,600.00	285,462,628.00	(6,255,972.00)	97.9
	Нэмэгдэл	11,964,830.00	11,964,828.00	(2.00)	100.0
	Унаа хоолны хөнгөлөлт	98,166,670.00	97,648,000.00	(518,670.00)	99.5
	ТУЗ	91,080,000.00	91,080,000.00	-	100.0
1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,209,700.00	54,556,284.40	(3,653,415.60)	93.7
	Тэтгэврийн даатгал	39,000,000.00	36,965,845.16	(2,034,154.84)	94.8
	Тэтгэмжийн даатгал	5,052,400.00	4,940,754.56	(111,645.44)	97.8
	ҮОМШӨ-ний даатгал	4,041,900.00	3,438,454.16	(603,445.84)	85.1
	Ажилгүйдлийн даатгал	1,010,500.00	671,784.60	(338,715.40)	66.5
	Эрүүл мэндийн даатгал	9,104,900.00	8,539,445.92	(565,454.08)	93.8
1.4	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,656,000.00	24,228,320.00	(427,680.00)	98.3
	Байрны түрээс	24,656,000.00	24,228,320.00	(427,680.00)	98.3
1.5	Хангамж бараа материалын зардал	20,503,400.00	20,490,912.00	(12,488.00)	100.0
	Бичиг хэрэг	7,171,400.00	7,171,375.00	(25.00)	100.0
	Тээвэр шатахуун	9,570,000.00	9,561,750.00	(8,250.00)	99.9
	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,610,000.00	1,606,367.00	(3,633.00)	99.8
	Бусад бараа ажил үйлчилгээний зардал	2,152,000.00	2,151,420.00	(580.00)	99.9
1.6	Нормативд зардал	4,000,000.00	3,972,200.00	(27,800.00)	99.3
	Сэлбэг	4,000,000.00	3,972,200.00	(27,800.00)	99.3
1.7	Удирдлагын зардал / томилолт/	600,000.00	196,750.00	(403,250.00)	32.8
1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	43,180,000.00	49,697,353.54	24,691,776.77	57.9
	санхүүгийн байгууллагын хураамж		68,000.00	68,000.00	
	Тээврийн хэрэгслийн татвар	245,800.00	245,800.00	-	100.0
1.10	Хөрөнгийн зардал	59,920,800.00	53,938,553.37	(5,982,246.63)	90.0
	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол		43,712,583.37	43,712,583.37	
	бараа үйлчилгээний бусад	8,540,000.00	8,531,370.00	(8,630.00)	99.9
	бусад урсгал шилжүүлэг	1,700,000.00	1,694,600.00	(5,400.00)	99.7
	Үйл ажиллагааны үр дүн		101,403,047.46	101,403,047.46	
	Үйл ажиллагааны бус зардал		61,252,022.52	61,252,022.52	
3	Төсвийн бусад мэдээллийн ангилал			-	
	Нийт ажиллагсдын тоо	14	13	-1	92.9
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	13	12	-1	92.3

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 1,168.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Аудитаар нийт 1,291.2 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 800.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 491.2 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1,291.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, зардалд хасаж тайлагнасан байна.	1	584.00	1	584.00			1	584.00				
Томилолт, бензений төлбөрийг Мөнгөн хөрөнгөд орлого аваагүйгээс орлого буурсан.	1	584.00	1	584.00			1	584.00				
Дүн	2	1,168.0	2	1,168.0			2	1,168.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр /

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Багануур үйлдвэр, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийслэлийн Багануур технологийн парк ХК-ийн гүйцэтгэл захирлын тушаал 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Багануур үйлдвэрлэл технологийн паркуудтай танилцах нөхөрсөг тэмцээн зохион байгуулах төсөв батлаж зарцуулсан байна.	1	800.0	1	800.0								
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оноос хойш шинэчлэн боловсруулаагүй, НББББ-ийг архивд эх хувиа 2024 онд өгсөн биетээр байгууллагад байхгүй байна.	1	-					1	-				
Тус байгууллага нь Төрийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд буюу Хувьцаат компани /хаалттай ХК/ бөгөөд зорилтот түвшиний төлөвлөгөө гүйцэтгэлийг, төсвийн гүйцэтгэлээр төлөвлөж тайлагнасан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг төрийн санд гаргаж хянуулж тайлагнадаг, Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн програмаар цалингаа боддог бөгөөд санхүүгийн тайлангаа төсвийн Си Ти Эс программаар гаргаж тайлангаа аж ахуй нэгжийн тайланд хөрвүүлэн гаргасан байна.	1	-					1	-				
НДШ-ийн өглөгийн тайлан нь тухайн байгууллагын тайлангаас нийгмийн даатгалын тайлангаас илүү тайлагнасан тулган шалгаж тооцоо нийлж алдааг залруулах.	1	491.2					1	491.2				
Дүн	4	1,291.2	1	800.0			3	491.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Багануур үйлдвэр, технологийн парк ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгарсан нийцлийн аудитаар 2 зөрчил³ илэрч 2 зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
1	БҮТП ХК нь 2025 онд нийт 1,288,219.9 мянган төгрөгийн 157 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас нийт 442,335.5 мянган төгрөгийн 145 мэдээлэл мэдээлж, хугацаа хоцроосон 10, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл, байна. Үүнд; Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 18 тушаал 386,482.1 мянган төгрөг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 мөнгөн гүйлгээ 366,652.3 мянган төгрөг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 12 мөнгөн гүйлгээ 92,750.2 мянган төгрөг, 5 мэдээллийг тус тус хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	-						1	-
Дүн		1	-					1	-	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
1	Тус байгууллагын хэрэгцээнд байгаа 89-16 УЕК улсын дугаартай тээврийн хэрэгсэлд албан хэрэгцээний ангиллын цэнхэр дугаар аваагүй байна	1	-					1	-	
Нийт дүн		2	-					2	-	

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

